



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 31 өдөр

Дугаар А/25

Мөрөн сум


Ажлын хэсэг байгуулж, хөрөнгө  
зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дуугаар зүйлийн 32.1.1, 32.1.12, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.1, 4.1, Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 68 дугаар тушаалын, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 01 сарын 13 ны өдрийн 03 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн нийт нутгаар хүйтний эрч чангарч, зарим сумдад өвөлжилт хүндрэх төлөвтэй байгаа тул Баянзүрх, Рэнчинлхүмбэ, Улаан-Уул, Цагааннуур, Хатгал, Алаг-Эрдэнэ сумдад эрсдэлийн үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар байгуулсугай.
2. Дээрх сумдад эрсдэлийн үнэлгээ хийхэд шаардагдах шатахуун, томилолтын зардалд 3,000,000 (гурван сая) төгрөгийг зарцуулсугай.
3. Дээрх зардлын 3,000,000 (гурван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.
4. Өвөлжилт хүндэрсэн сумдад эрсдэлийн үнэлгээг үр дүнтэй зохион байгуулж, дүгнэлтийг аймгийн Онцгой комиссын хуралд 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Л.Бямбасүрэн)-д үүрэг болгосугай.
5. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА

ШИДЭРБАЯСГАЛАН




Захирамж-2023

6712010689



Аймгийн Засаг даргын 2023 оны  
01 дүгээр сарын 31-ны өдрийн  
А/25. дугаар захирамжийн хавсралт



ЗУДЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН  
ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Л.Бямбасүрэн

(ОБГ-ын Гамшгаас хамгаалах Улсын хяналтын  
ахлах байцаагч Хошууч)

Гишүүд: М.Баттулга

(Баянзүрх сумын Засаг даргын тамгын газрын  
дарга)

О.Энхтүвшин

(Рэнчинлхүмбэ сумын Засаг даргын Тамгын газрын  
дарга)

М.Батцогт

(Улаан- Уул сумын Засаг даргын Тамгын газрын  
дарга)

Ё.Даваа

(Алаг-Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын  
дарга)

Я.Эрдэнэжав

(Цагааннуур сумын Засаг даргын Тамгын газрын  
дарга)

Д.Сайнбаяр

(Хатгал тосгоны Захирагчийн ажлын албаны дарга)

Сумдын Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн

Сумдын Ус цаг уур орчны шинжилгээний төвийн техникч, харуул

Нарийн бичгийн дарга:

Б.Бямбасүрэн

(Хүнс, Хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны  
дарга)

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_